



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар A/995

Улаанбаатар хот

Нийслэлийн Төр захиргааны авто бааз
УТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц,
орон тооны хязгаарыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг нэгдүгээр, дүрмийг хоёрдугаар хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар (М.Баяраа), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Т.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/583, 2019 оны А/938 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ


Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
 12 дугаар сарын 21-ны өдрийн
 .../.../2021 дугаар захирамжийн
 1 дүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗЫН
 ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР

Хэлтэс, нэгж		Орон тоо
1	Дарга	1
Захиргаа, хүний нөөцийн хэлтэс		9
1	Хэлтсийн дарга	1
2	Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан	1
3	Хүний нөөцийн ажилтан	1
4	Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан	1
5	Үйлчилгээний ажилтан	1
6	Манаач	4
Санхүү, төлөвлөлтийн хэлтэс		3
1	Хэлтсийн дарга	1
2	Эдийн засагч, нягтлан бодогч	1
3	Техникч-нярав	1
Тээвэр зохицуулалтын хэлтэс		92
1	Хэлтсийн дарга	1
2	Ашиглалтын инженер	1
3	ХАБ инженер	1
4	Диспетчер-механик	12
5	Үйлчилгээний жолооч	74
6	Механик засварчин	2
7	Сантехникч	1
Хэлтэс 3, нийт албан хаагчийн тоо 105 үүнээс Дарга-1		Нийт 105

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 21-ны өдрийн
А/013 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТУГ-ЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 3-т зааснаар: Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил үйлчилгээг эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

1.2. Нийслэлийн Төр захиргааны авто бааз нь (цаашид "Авто бааз" гэх) Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлагууд, газар албадын албан ажил үйлчилгээнд автомашинаар үйлчлэхэд тусгагдсан бодлого, удирдамжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Нийслэлийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар мөн.

1.3. Авто баазын зорилго нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гаргасан чиг үүрэг, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэх, Төрийн үйлчилгээнд мэргэжлийн өндөр чадвартай боловсон хүчнээр хөнгөн шуурхай, соёлтой үйлчилж, хүлээсэн үүргээ биелүүлэхэд оршино.

1.4. Авто бааз нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын захирамж, тогтоол, шийдвэр, байгууллагын дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.5. Авто бааз нь тогтоогдсон журмаар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, Төрийн сан /банк/-д харилцах данстай байх бөгөөд өөрийн туг, бэлгэдэлтэй байж болно.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Авто баазын даргыг ажилд томилох буюу ажлаас чөлөөлөхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч шийдвэрлэнэ.

2.2. Авто бааз нь Нийслэлийн Засаг дарга, орлогч нар, Тамгын газрын дарга болон Нийслэлийн өмчийн харилцааны удирдлагад байгууллагын үйл ажиллагааны явц, ажлаа танилцуулж, тайлагнана.

2.3. Авто баазын дарга нь төсвийн Ерөнхийлөн захирагчтай "Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ" байгуулан ажиллана.

2.4. Авто баазын даргыг ээлжийн амралт, өвчтэй, чөлөөтэй, удаан хугацааны сургалт, томилолтын хугацаанд нийслэлийн Төр захиргааны авто баазын Ерөнхий инженер орлоно.

2.5.Авто баазын дарга нь авто баазын эрхэм зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд эрхлэх асуудлын хүрээнд тушаал, шийдвэр гаргана.

2.6.Авто баазын дарга нь батлагдсан орон тоо, бүтэц зохион байгуулалтыг үндэслэн ажиллагсдыг ажилд томилж, чөлөөлж ажиллана.

2.7.Авто баазын дарга нь холбогдох хууль тогтоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтан, албан хаагчдын цалингийн шатлал, шагнал, урамшууллын хэмжээг тогтоож, хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлнэ.

2.8.Ажилтнуудын ажлын гүйцэтгэлээр үнэлэх, дүгнэлт өгч, дотоод журмын дагуу шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гадаад, дотоодын сургалтад хамруулан ажиллана.

2.9.Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, ажлын байрны тав тухтай байдлыг хангаж, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

2.10.Авто бааз нь өдөр тутмын үйл ажиллагаагаа холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, жил, улирлын ажлын төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээ, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтын дагуу явуулна.

2.11.Авто баазын дарга нь холбогдох хууль тогтоомж, удирдах дээд байгууллага болон энэ дүрмээр олгогдсон бусад эрхийг эдэлнэ.

Гурав. Санхүүжилт

3.1.Авто бааз нь Төрийн ажил үйлчилгээ үзүүлэхэд Нийслэлийн төсвөөс санхүүжилт авч, төсвөөс олгосон хөрөнгийг "Төсвийн тухай" хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнаж ажиллана.

3.2.Авто баазын орлого нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Засаг даргын Тамгын газар, хэрэгжүүлэгч агентлагууд, газар, алба, дүүргүүдэд тээврийн үйлчилгээг хүргэж үзүүлсний болон бусад орлогоос бүрдэнэ.

Дөрөв. Авто баазын үүрэг

4.1.Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулан, байгууллагуудад автомашинаар үйлчлэх

4.2.Үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслийн болон Төрийн үйлчилгээний соёлд тавигдах шаардлага, стандарт, норм, нормативыг мөрдөх, соёлч боловсон, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх

4.3.Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан балансыг зохих хугацаанд гаргах

4.4.Байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг мэргэжлийн өндөр боловсролтой, дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, жолооч нарын боловсрол, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар ажил зохиох

4.5.Авто үйлчилгээнд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах, жолооч нарын ангилал дээшлүүлэх, сургах, мэргэшүүлэх, хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах

4.6.Шатахуун, тослох материал, автомашины сэлбэг, дулаан, цахилгаан, усны үнэ нэмэгдэхэд үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар бусад холбогдох газруудтай хамтран боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулан, шийдвэрлүүлэн, мөрдөж ажиллах

Тав. Авто баазын эрх

5.1.Авто баазын хөрөнгийг Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, захиран зарцуулах

5.2.Авто баазын хариуцах асуудлаар холбогдох байгууллагатай бие даан болон Нийслэлийн Засаг даргын зөвшөөрөлтэйгөөр гэрээ хэлэлцээ хийх, бусад асуудлаар хамтран ажиллах

5.3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч болон Нийслэлийн Өмчийн харилцааны газрын зөвшөөрлөөр норм, хугацаа дууссан автомашин, тоног төхөөрөмжийг дуудлага худалдаагаар оруулах, худалдах, шилжүүлэх

5.4.Парк шинэчлэлтэд зориулж автомашин шинээр худалдаж авахдаа Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран ажиллах

Зургаа. Бусад зүйл

6.1.Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

6.2.Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр зохих байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.